



Үндэсний геологийн албаны 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 1/403 дугаартай албан бичгийн 4 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛООР БАТЛАГДСАН “УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НД ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ ХАРИУЦАН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

2025 он

№	Бодлогын үндэслэл	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	Үр дүнгийн үзүүлэлт		2025 онд шаардлагатай хөрөнгө		Үндсэн хариуцагч /АҮЭБЯ/	Хамтран хариуцагч /УГА/
				Суурь түвшин /2024 он/	Зорилтот түвшин /2025 он/	Санхүүжилтийн хэмжээ /сая.төг/	Санхүүжилтийн эх үүсвэр		Тайлан
0	1	2	3	4	5	6	7	8	9
“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО: ЭДИЙН ЗАСАГ БҮЛГИЙН ХҮРЭЭНД.									
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛНЭ.									
1	МУХТЖҮЧ -6.3.4, ЗГҮАХ-3.3.1.2	1.4.1.1 Агаарын геофизикийн судалгааны ажлыг гүйцэтгэх	Талбайн хамрагдалт	66	50%	21 тэрбум	Улсын төсөв	1. Соронзон-2023 төсөл “Геологийн судалгаа-шинжилгээний төв” ТӨҮГ болон “Икскалибур авиашн ХХК”-ны түншлэлийн хүрээнд судалгааны шинэ арга аргачлал болох агаарын хүндийн хүчний градиометр (AGG) судалгааг болон агаарын соронзон, агаарын радиометр (Mag+Rad)-ын хэмжилтийг комплекс хэлбэрээр нийт урт 4164 т.км агаарын нислэгийн ажлыг 100% гүйцэтгэн, датаг боловсруулсны үр дүнд Хөх нүдэн, Мөргөцөг, Баянхошуу,	

							Далайн дуулга уул эрлийн талбайг ялган, газрын нарийвчилсан 1492 т.км соронзон судалгаа, цэг хооронд 100м зайтай 9 шугамаар нийт 280 ф.цэгийн ТЕМ буюу цахилгаан соронзон хайгуулыг, цэг хооронд 100м зайтай янз бүрийн чиглэлтэй 10 шугамаар нийт 400 ф.цэгийн хүндийн хүчний орны судалгааг хийж үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хурлаар оруулж хэлэлцүүлнэ. 2. Агаарын геофизик-2024 төслийн хүрээнд Агаарын геофизикийн 1:200000-ны масштабтай цогцолбор судалгааны ажил: Агаарын геофизик-2024 төслийн хүрээнд өнөөдрийн байдлаар Агаарын геофизикийн “Tempest” цахилгаан соронзон болон нэмэлтээр нэгэн зэрэг хэмжих багажууд болох Scintrex CS-3 соронзон орны, RS радиометрийн, iCORUS хүндийн хүчний төхөөрөмжүүдээр талбайн геофизикийн цогц системээр хэмжилт, боловсруулалтын ажлыг гүйцэтгэсэн бөгөөд энэ онд гүйцэтгэх төсөв, төлөвлөгөөг ЭБМЗ-ийн хурлаар оруулж батлуулсан. Өнөөдрийн байдлаар төлөвлөгөөний дагуу геофизикийн хэмжилтийн нислэгийн ажил бүрэн хийгдэж, газрын шалгалт, дээжлэлтийн ажил, үр дүнгийн тайлан боловсруулсан. 3. Агаарын геофизик-2025 төсөл: Монгол орны Хангайн бүсийн хэмжээнд 135,766.8 кв.км талбайд Агаарын
--	--	--	--	--	--	--	---

								соронзон, гамма цацрагийн спектрометр (нийлбэр цацраг, уран, тори, кали) болон дагалдах судалгааг хийх Агаарын геофизик-2025 төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан. Гүйцэтгэгчээр Гео сан ХХК шалгарч гэрээ байгуулан судалгааны ажлыг эхлүүлж 2025 онд 5 сувгийн хэмжилтийн нислэгийг 42700 тууш/км буюу нийт судалгааны талбайн 50%-ийг хамруулан хэмжилтийн ажлыг гүйцэтгэсэн.
2	МУХТЖҮЧ-6.3.4, ЗГҮАХ-3.3.1.2	1.4.1.2. Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн хэтийн төлөвийн судалгаа хийх	Хэрэгжих төсөл	2	1	-	Улсын төсөв	Өндөр технологийн түүхий эдийн хэтийн төлөвийн судалгааны ажлын ӨТТЭ-2 төсөл. Өндөр технологийн түүхий эд II төсөл нь /ГХЭ, лити, берилли, никель, кобальт, бал чулуу/-ийн эрлийн ажил болон тэдгээрийн хэтийн төлөвийг тодорхойлон үнэлгээ өгч, тайлбар бичиг, мэдээллийн сан бүхий үр дүнгийн тайлан зохиогдсон. Өмнөх судалгааны ажлаар бүртгэгдсэн нийт 1156 илрэл, эрдэсжсэн цэгүүдээс 780 объектыг ялган авч, хээрийн судалгаанд хамруулсан. Эрлийн нарийвчилсан 8 талбайн хэмжээнд хэтийн төлөвийг тодорхойлсон: ГХЭ- 10 илрэл, 1 эрдэсжсэн цэг, (Li-Be)- 10 илрэл, Ni (Co)- 2 илрэл, Ni (Cr)- 2 илрэл, Ni (Sb)- 2 илрэл, Ni-1 илрэл, бал чулууны 3 илрэл. Үүнээс баялаг тооцсон нь: ГХЭ-ийн нэг илрэлд Р зэргээр 6,750 тн TR; гурван илрэлд С

								зэргээр 46.26 тн болон арван илрэлд Р зэргээр 4517.89 тн TR_2O_3; хоёр илрэлд ГХЭ-ийн нийлмэл ислийн металл С зэргээр 36.14 тн болон Р зэргээр 278.48 тн; Ni-Co-ийн нэг илрэлд Р зэргээр 52,684.8 тн Ni, 940.8 тн Co, 10,348.8 тн Cr, 3,246,566.4 тн Mg, бал чулууны хоёр илрэлд Р зэргээр 210,012.3 тн баялаг тооцсон үр дүнгийн тайлан зохигдож, ЭБМЗ-ийн 2025 оны 11 дүгээр сарын 05-ний өдрийн хурлаар орж хамгаалагдсан.
--	--	--	--	--	--	--	--	---

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБА

2025 оны 12 дугаар сарын 17